

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн! АНХ ДЭГДЭЭР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жилдээ

№ 76 (2380)

1974 оны 10 дугаар сарын 10

ПҮРЭВ

МАЛЫН ЗҮЙ БУСЫН ХОРОГДЛЫГ БАГАСГАЯ

Малын зүй бус хорогдлыг багасгах талаар нам, засгаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд тус аймгийн нам, улс, ХАА-н байгууллага, нийт малчид идэвх чармайлтаа дайчлан ажиллаж байгаагийн үрээр аймгийн хэмжээгээр 538,7 мянган төл бойжуулан авч өнгөрсөн оныхоос төлийн хорогдлыг 32,8 хувь, том малын хорогдлыг 36,3 хувиар багасгав.

Үүний үрээр олонхи сумд мал өсгөх 1974 оны төлөвлөгөөг биелүүлэх сайхан боломжийг бүрдүүлэв.

Угтаал, Баянцогт, Дэлгэрхаан сумдын том малын хорогдол бусад сумдаас харьцангуй бага, Баянцагаан, Алтанбулаг зэрэг сумд төл ба том малын хорогдлыг өнгөрсөн оны энэ үеийн хэмжээнээс багасгажээ. Гэвч Баянжаргалан, Заамар, Лүн, Эрдэнэ, Эрдэнэсант сумдад том малын хорогдол бусдаасаа их байгаагийн дотор Өндөрширээт, Баянжаргалан, Лүн, Заамар сумдын малын хорогдол өнгөрсөн оны энэ үеийнхээс ихэссэн байна.

Энэ бол орон нутгийн нам, улс, ХАА-н байгууллагаас мал аж ахуйн ажиллагааг эрчимжүүлж хорогдлыг багасгах зорилтыг амьдралд хэрэгжүүлэн олон түмний идэвх хөдөлгөөнийг өрнүүлэх, МАА-н мэргэжилтний хариуцлага санаачлагыг дээшлүүлэх талаар зохион байгуулалтын тодорхой ажил зохиогоогүй, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг сулруулсантай холбоотой юм. Зарим сумд урин дулаанд тайвшран эмчилгээ тэжээлийн цэгийн ажиллагааг сулруулж малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдаж явуулсны улмаас зөвхөн III улиралд хорогдуулсан малын тоо урьдах 2 улиралд хорогдсонтой тэнцэж байна.

Малын зарим эмч нар малыг өвчнөөс урьдчилан сэргийлж, өвчтгийг эмчлэн эдгэрүүлэх талаар дорвитой үр дүн гаргахуйц хариуцлагатай ажиллахгүй байна. Энэ байдалд аймгийн мал эмнэлгийг удирдах газар дүгнэлт хийж, эмч мэргэжилтэн нарын ажлын хариуцлагыг дээшлүүлэх шийдвэртэй арга хэмжээ авбал зохино.

Малын зүй бус хорогдлыг багасгах гол нөхцөл болсон эмчилгээ тэжээлийн цэгийн хүч чадлыг зарим газар бүрэн ашиглахгүй зусланд гарсан нэрээр түүнийг тарааж олгогдсон авто машингүй үр бүтээлгүй ажилдуулж байгаагийн гадна Баян, Баянжаргалан сумд улсын төсөвт цэгийн барилгыг одоо хүртэл барьж дуусгаагүй байна. Эмчилгээ тэжээлийн цэг бүрийг зохистой ажиллуулж МАА-н өвлийн бэлтгэлийг яаралтай хангаж, нийт мал ялангуяа өсвөрийн малын өвөлжилтийг сайн зохион байгуулж мал бүрийг эрүүлжүүлэн малын хорогдлыг зогсоох хариуцлагатай зорилт ХАА-н байгууллага, малчид, хөдөлмөрчдийн өмнө зогсож байна. Малын тоо толгой өсч, олон тооны суурь шинээр нэмэгдэж байгаа учир нэгдэл, САА-нууд дотоод бололцоогоо шавхан дайчилж, ажиллах хүчийг нэмэгдүүлэн зөв хуваарилах явдал малын хорогдлыг багасгахад чиглэсэн зохион байгуулалтын нэг чухал арга хэмжээ болно.

Аймгийн хэмжээгээр IX сарын сүүлчээр мал сүргийн толгойн хамгаалалтад явуулсан шалгалтын мөрөөр сум бүр зохион байгуулалтын шуухай арга хэмжээ авч малын хорогдлыг эрс багасгах явдал шаардагдаж байна. Малын хорогдлыг багасгах ажил эрхэлсэн аймаг, сумдын комисс, АХШБ-ын ажлыг улам эрчимжүүлж, хяналт шалгалтыг үр бүтээлтэй болгон малын хорогдлыг багасгах талаар гарсан тогтоол шийдвэрийн заалт бүрийг хэрэгжүүлэхэд сумдын нам, захиргааны байгууллага онцгой анхаарвал зохино.


Мал өвөлжилтийг сайн зохион байгуулж, малын зүй бус хорогдлыг эрс багасгаснаар 1974—1975 оны мал өсгөх улсын төлөвлөгөө, улмаар улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх V таван жилийн төлөвлөгөөг биелүүлэх чухал үндэс болно.

Иймээс малын зүй бус хорогдлыг багасгах тэмцэлд орон нутгийн нам, улсын байгууллага бүх нийтийн хүчийг чиглүүлэн ажиллах хэрэгтэй.

ЦАХИЛГААН УТАС СОЛИЛЦОВ

Монгол—Зөвлөлтийн найрамдлын уламжлалт 23 дахь сарын ажил эхэлсэнтэй холбогдуулан ЗХУ-ын Курган мужийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Кинязев Филипп Кириловичид тус аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ц. Адъяа баарын цахилгаан утас илгээж, хариу цахилгаан хүлээн авлаа. Цахилгаан утсанд өгүүлэхдээ:

Монгол анд нэхөлдөө манай хоёр орны уламжлалт найрамдлын сарын ажил эхэлсэнтэй холбогдуулж чин сэтгэлийн халуун баярыг хүргэж, МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн түүхт ойнуудыг угтсан социалист уралдаан, өдний засаг соёлынхоо бүтээн байгуулалтанд улам их амжилт гаргахыг Төв аймагчууддаа хүсэн ерөөсөн байна.



Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Чечено—Ингушийн автономит улсын “Шелковской” САА-н хоньчин Наурды Демухамбетов 30 гаруй жил хоньчноор ажиллажээ.

Наурды Демухамбетов Лениний одонгоор 2 удаа, октябрийн хувьсгалын одонгоор 1 удаа шагнагдсаны дээр энэ жил социалист хөдөлмөрийн баатар цол хүртсэн юм.

Тэрээр хонь бүрээс 8,7 кг ноос, 100 эхээс 140 төл бойжуулж хамгийн өндөр амжилтанд хүрчээ.

Н. Демухамбетов ооринхоо туршлагыг залуу хоньчдод эзэмшүүлдэг аж.

ЗУРАГ ДЭЭР: (баруун гараас) Социалист хөдөлмөрийн баатар, хоньчин Н. Демухамбетов. (зүүн гараас) хонин сүрэг бэлчээрт.

ТАСС-ын гэрэл зураг:

ТАРИАЛАНЧДЫН АМЖИЛТ

Эрдэнэсантын ТАА-н нам, захиргаа, олон нийтийн байгууллага тариа хураалтын ажлыг богино хугацаанд чанартай дуусгаж улсын төлөвлөгөөг давуулан биелүүлэхийн тулд үзэл суртал зохион байгуулалтын тодорхой ажил зохиожээ.

Аж ахуйн захиргаа, үйлдвэрийн эвлэлийн хороо, техникчид, оюутан сурагчид, тээвэрчдийн дунд 3, 5, 7 хоногийн болзолт уралдаан зарлаж түүнийгээ тогтмол дүгнэж шагнаал урамшил олгохын зэрэгцээ техникчид, комбайнчдын өдөр бүрийн ажлын гүйцэтгэлийг аж ахуйн хэмжээгээр нэгтгэн самбарт байр эзлүүлэн хөтлөж ЗХУ-ын Алтайн хязгаарын намын байгууллагын туршлагаар “Хөдөлмөрийн алдар” самбарт тэргүүний хүмүүсийн ажлын амжилтыг бичиж нийтэд сурталчилж байна.

Тэрчлэн 200 га ангилан хадсан буюу 1000 центнер ургац цайруулсан комбайнчдын коомбайнд нь тус бүр нэг таван хушуу зурж таван хушуу бүрт 25 төгрөгийн шагналыг олгож байна.

Тариа хураалт, сүрэл боолт, цэвдэгш хагалгаанд тавих хяналт шалгалтыг тогтмолжуулж ур тариаг хаягдалгүй хураахын төлөө сумын ардын хянан шалгах хороо, булсад олон нийтийн бай-

гууллагатай хамтран ажлын чанарын тоголдол, хаягдалтай тэмцэх эргүүл постыг гаргажээ. Тариа хураалтанд ажиллаж байгаа хүмүүсийн соёл ахуйн үйлчилгээ, хөдөлмөр хамгааллын асуудалд байнга анхаарч дутагдалтай зүйл дээр шуурхай арга хэмжээ авч байна.

Үүний дүнд нийт тариаланчдын хөдөлмөрийн идэвх өрнөж бахдам сайхан амжилт гаргаж байна.

Тус аж ахуйн хамт олон цаг агаарын сааталхтэй нөхцөлд цагийг сайн ашиглаж, техникийн эвдрэл саатай гаргалгүй хүч чадлыг гүйцэд ашигласан үндсэн дээр хураах бүх талбайнхаа 90 гаруй хувийг ангилан халаж 50 гаруй хувийг нь цайруулаад байна.

Цэндбаяр даргатай ур тарианы, З. Лхагвасүрэн даргатай 4 дүгээр бригадууд хураах талбайнхаа 75—80 хувийг нь цайруулж нэг га-гаас 11,3—13 центнер ургац авч бусад бригадаас түрүүлж явна. Аж ахуйн хэмжээгээр ургац хураалтанд ажиллаж байгаа бүх техникчдийн 70 орчим хувь нь өдөр бүрийнхээ төлөвлөгөөг биелүүлж байгаагийн дотор улсын 3 удаагийн аварга комбайнчин Ухнаа, Цэдэнсодном, улсын 2 удаагийн аварга комбайнчин Цэгмид, Октябрь, Чулуун, залуу комбайнчин Мөнхөө,

Даваа кав, Нямсүрэн, Зөвлөлтийн комбайнчин И.И. Новиков Ю. Г. Лесков И.И. Сопожнов В.И. Макаренко В.И. Иванов нарын олон хүн өдөр бүрийнхээ төлөвлөгөөг 10,6—39,2 хувиар давуулан биелүүлж аж ахуйгаас зарласан уралдааны болзлыг 1—3 удаа ханган 1—2 мөнгөн таван хушуу хүлээж аваад байна.

Баяндэлгэр сумын “Хэрлэнбаян” нэгдлийн тариаланчид малын таримал тэжээл хураах ажлыг дуусгачад ур тариа хураах ажилд эрчимтэй орж ажлын 6 хоногт 1200 тонн ур тариа цайруулж үтрэмд буулгаад байна.

Намрын ургац хураалтанд туслахаар ЗХУ-аас уригдан ирээд ажиллаж байгаа социалист хөдөлмөрийн баатар, комбайнч Н.Г. Гибалов, А.Т. Шеренко, нэгдлийн тэргүүний комбайнч, МХЗЭ-ийн Төв Хорооны алтан медальт Лувсанцэрэн, комбайнч Бадарч, Лантуу нар 130—140 тонн ур тариа цайруулж бусдыгаа хошуучилж явна.

Тариалангийн талбайгаас үтрэмд будаа тэжээрд ажил амжилттай явагдаж жолооч Осоржам, Бямбасүрэн нар ажлын 5 хоногт 152—170 тонн ур тариа үтрэмд буулгаж уралдаанд тэргүүлэв.

Ц. ДАШНЯМ

БАЙГУУЛАГДСАНЫ 50 ЖИЛИЙН ОЙД

ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ МОЛДАВ УЛС

1940 оны 8 дугаар сард ЗСБН Молдав улс байгуулагджээ.

ЗСБН Молдав улс 3 сая 773 мянган хүн ам, 33,7 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай.

1924 оны 12 дугаар сард бүх Молдавын намын анхдугаар бага хурдаар мужийн намын байгууллага байгуулагдаж улмаар 1940 онд бүх холбоотын коммунист (большевикуудын) Намын Төв Хорооны шийдвэрээр Молдавын мужийн намын байгууллага нь Молдавын коммунист (большевикуудын) нам болон өөрчлөгдөн байгуулагджээ.

Социал-Демократын дугуйлан, Оросын ажилчин социал-демократ намын жижгэвтэрхэн дугуйлан бүлгэмээс байгуулагдсан Молдавын коммунист нам одоо өгнөөндөө 124,0 мянган гишүүн, анхан шатны 3719, хот районы намын 40 байгууллагатай коммунист намын томоохон байгууллага болтлоо өсчээ.

Тус бүгд найрамдах улсын үйлдвэрлэх хүчний гол үндэс бол машины хүнд үйлдвэр, хүчирхэг эрчим хүчний бааз мөн.

Молдавын аж үйлдвэр нийгмийн нийт бүтээгдэхүүний 55,6 хувийг гаргаж байна.

Тус улсад аж үйлдвэрийн зэрэгцээгээр машин, нарийн багаж хэрэгсэл, электроникийн үйлдвэрүүд хурдан хөгжиж байна. Дайнаас хойш аж үйлдвэрийн 230 орчим том газрууд байгуулагджээ.

Урьдын Молдавт эрчим хүч хангалтгүй хөгжиж байсан болоодоо бүх хамтрал, САА-нууд улсын эрчим хүчний системд хол-

богдож, бүх тосгон суурин, мал аж ахуйн ферм, тариалангийн тасаг, бригад, хээрийн байрууд бүрэн цахилгаанжжээ.

Эрчим хүчний гол хослол Молдаваас Украины олон район, «Мир» нэгдсэн системээр дамжин эрчим хүч нь БНБАУ-д хүрдэг. Дэлхийн бүх тивийн 50 гаруй улс оронд Молдавт үйлдвэрлэсэн чанар сайтай бүтээгдэхүүн үүний дотор машины болон нарийн багаж хэрэгсэлийн 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг нийлүүлж байна.

Тус Бүгд найрамдах улсад хүнсний аж үйлдвэр цоо шинээр байгуулагдсаны гадна жимсний архин бүтээгдэхүүн дээгүүр байр эзэлдэг.

Жимсний архин бүтээгдэхүүн бүх холбоотын болон олон улсын тэмцээний алт, мөнгөн медаль 200 гаруйг хүртжээ.

Тус бүгд найрамдах улс нь ХАА-д тохиромжтой 2,7 сая га газартай бөгөөд жилд 2,1 миллиард рублийн үйлдвэрлэл явуулж байна.

ХАА-н нийт бүтээгдэхүүн нь 1973 онд 1940 оныхоос 3,4 дахин өсчээ.

ЗСБН Молдав улсад гэгээрэл, соёл, шинжлэх ухаан асар түргэн хөгжиж байна.

Ерөнхий боловсролын 2140 сургууль, тусгай мэргэжлийн 46 дунд сургууль, их дээд 8, техник мэргэжлийн 70 гаруй сургууль тус тус ажиллаж байна.

100 мянган хүн амд ноогдож байгаа оюутны тоогоор Европын хөрөнгөтөн орнуудаас хол түрүүлжээ.

Н. ХАНДСҮРЭН

КОММУНИЗМЫН МОРНЬ

ЗХУ-ЫН ХАА-Н ХӨГЖИЛТ

ЗХУ, IX таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилд ХАА-д 72 миллиард рублийн хөрөнгө оруулсны гална 1973 онд ХАА-н нийт бүтээгдэхүүн 1966—1970 оны жилийн дунджаас 19,6 хувиар өсчээ. Хамтрал, САА-нууд 1973 онд өөрийн түүхэндээ хамгийн их ургац 222,5 сая тонн үр тариа хурааж гарамгай амжилт гаргав.

1974 онд ХАА-н нийт бүтээгдэхүүн 100 гаруй миллиард рубль болж өнгөрсөн оныхоос 6,4 хувиар давж, улсад үр тариа 84,0 сая тонн, чихрийн манжин, наран цэцэг, түүхий хөвөн зэрэг бусад ургамлын бүтээгдэхүүн 100 шахам сая тоныг нийлүүлнэ.

Жилийн дунджаар үйлдвэрлэж байгаа мах (амьдлын жингээр) өнгөрсөн 3 жилд урьдах VIII таван жилийнхээс 17 хувиар ихэсчээ. Энэ онд 63,0 мянган өсвөрийн үхэр, нэг сая гаруй гахай, 30 сая гаруй шувуу бордох чадалтай МАА-н иж бүрэн төв, шувуун фабрикууд ашиглалтанд орно.

Хамтрал, САА-нууд бүрэн цахилгаанжиж, хамтралын тариачин, САА-н ажилчин өрхийн 98 хувьд нь цахилгаан нэвтэрчээ.

1973 онд ХАА-д 60 миллиард көт цаг цахилгаан хэрэглэж байсан бол 1975 онд 75,0 миллиард болон өсч 1940 онд улс ардын бүх аж ахуйд хэрэглэж байснаас 1,6 дахин өсөх юм. Атар газар эзэмшсэн өнгөрсөн 20 жилд 31,0 миллиард пүү үр тариа ургамлын бусад бүтээгд-

хүүнийг атраас хураажээ.

Төлөвлөгөөт таван жилийн эхний 3 жилд ХАА-д 948 мянган трактор, 581 мянган тээврийн болон тусгай зориулалттай автомашин, 273 мянган үр тарианы комбайн, ХАА-н олон техник багаж төхөөрөмж нийлүүлжээ.

ЗХУКН-ын Төв Хорооны 1966 оны V сарын бүгд хурлаас хойших хугацаанд услаж, хатаасан 11 сая орчим га тариалангийн талбайг ашигласан бөгөөд энэ онд зөвхөн улсын хөрөнгө оруулалтаар 862 мянган га талбайг ашиглана.


ЗХУ-д тариалангийн селекцийн 30 орчим төв ажиллаж байгаагийн 20 нь үр тариа, тосны ургамлаар бусад нь тэжээлийн үр-

гамлаар селекц эрдэм шинжилгээний ажил хийж байна.

Үүний үрээр «Миросовская—808» гэдэг сортын улаан буудай, ган хүйтэнд тэсвэртэй арвин ургац өгдөг зэрэг хосолом «Ростовчанка», «Прибой», «Альбидум—114» өвөлждөг улаан буудайг өргөнөөр нэвтрүүлж байна. 1973 онд ХАА-н үйлдвэрлэлд 75,4 мянган шинэ санаачилга нэвтрүүлсэн нь 61 сая 400 мянган төгрөгийн үр ашиг өгчээ.

ЗХУ-д мал аж ахуйн үндсэн бүтээгдэхүүн асар их хэмжээгээр өсч 1940 онд 4,7 сая тонн мах (ялдалсан жингээр) үйлдвэрлэж байсан бол 1973 онд 13,5 сая тонн болж бараг 4 дахин өсчээ. 1973 онд 87,2 сая тонн сүү үйлдвэрлэсэн нь 1940 оныхоос бараг 3 дахин их болов.

1973 онд 50,8 миллиард ширхэг өндөг үйлдвэрлэсэн нь 1940 оныхоос 4 дахин, 1970 оныхоос 10,1 миллиард ширхэгээр илүү болжээ.



Оренбургт баригдаж байгаа хийн иж бүрэн төв нь улс орныхоо эрчим хүчийг нэмэгдүүлэх тодиргүй хийний аж үйлдвэрт хамд үнэтэй түүхий эд өгөх юм. Тус төвийн хамт олон энэ онд 11 миллиард, 1975 онд 30 миллиард шоометр түүхий эд олзворлоно.

ЗУРАГ ДЭЭР: Оренбургийн хийн иж бүрэн төв тоноглогдож байна.

ЖУЖИГЧНИЙ УРАН ЧАДВАР

Урлагийг хүмүүсийн хүсэл бодол, оюун санаанд хүргэж, хөдөлмөр тэмцэл зоригжуулагч болгон хэрэгжүүлэхэд жүжигчний уран чадвар их үүрэг гүйцэтгэнэ.

Жүжигчний уран чадвар гэдэг нь биеийн, хэлний, сэтгэхүйн гэсэн 3 ойлголтод нэгдэж байдаг. Энэ гурав нь жүжигчинд заавал байх шаардлагатай. Учир нь амьдралын үнэнийг жүжигчин хүн тайзан дээрээс биеэрээ үзүүлж оюун ухаанаараа сэтгэж, хэл яриагаараа илэрхийлж байдаг онцлогтой.

Орос, Зөвлөлтийн театрын урлагийг үндэслэгч, нэрт найруулагч К. С. Станиславский «Жүжигчин хүний бие, баримлын шавар шиг байх ёстой» гэж хэлсэн байхад Оросын нэрт жүжигчин Салавин «Жүжигчин хүний зөвхөн гарт нь 40000 хө-

дөлгөөн оршиж байдаг» гэж тодорхойлжээ.

Энэ хоёр жишээ нь жүжигчин хүн бодож байгаа бодол, хэлж ярих гэсэн үгээ хөдөлгөөнөөрөө илэрхийлж чадахаар уран чадварлаг, уян налархай тоглохыг хэлж байгаа хэрэг юм.

Үүнтэй холбогдуулж жүжигчний уран чадварыг нэмэгдүүлэх зарим аргыг авч үзье.

Үүнд: биеийн болон сэтгэхүйн үйлдлийг хөгжүүлэх зорилгоор үггүй этюд (амьдралын аливаа үзэгдлийг хөдөлгөөн сэтгэхүйгээр дүрслэх дасгал) хийх явдал юм.

Этудийг хийхдээ гадна талаас нь дууриах биш биеийн ба сэтгэхүйн үйлдлийг хослуулж амьдралын үнэнийг үзүүлэхэд оршино. Жүжигчин хүн үгийн үйлдлийг хөгжүүлэхийн тулд түргэн хэллэг, хурдан уншлагын дасгалыг

байнга хийж байх шаардлагатай. Сэтгэхүйн үйлдэл бол жүжигчин хүний чадварыг илэрхийлэх гол чанар мөн.

Энэ нь тухайн тоглож байгаа ролийн зан чанар, ахуй амьдрал, ааш араншинг амьдрал дундаас судлаж олоод түүнээс итгэж тоглохыг хэлнэ. Сэтгэхүйн үйлдлийг хөгжүүлэх үндсэн дасгал бол үггүй этюд юм. Ер нь жүжигчин хүн өөрөө бүтээлч идэвх гаргаж бие дааж ажилласнаар уран чадвараар өсч сайн жүжигчин болох нөхцлийг бүрдүүлдэг. Жүжигчний дүртэй ажиллах ажиллагааг сургуулилын, сургуулилын бус (биеэ дааж) гэж 2 хуваадаг ба жүжигчний биеэ дааж ажиллах нь уран чадвараар өсөхийн үндэс мөн.

К. С. Станиславский «Дүр бүтээхэд зарцуулах нийт хөдөлмөр, цаг хуга-

цааны 90—ээс доошгүй хувийг жүжигчний биеэ дааж ажиллагаа эзлэх ёстой» гэжээ. Роль авсан жүжигчин биеэ дааж ажиллахаас өмнө жүжгийн үндсэн санаа, болж буй цаг үе, газар орон, өөрийн гаргах дүрийн зан чанар, аж амьдрал, үйл явдлыг тогтоосны дараа сая бие дааж ажиллах ёстой.

Жүжигчин хүн бүтээх ролю таван хуруу шигээ мэдэж судлах явдал чухал байдаг.

Энэ нь жүжигчний уран чадвараа сайжруулахын бас нэг нөхцөл болно.

Амьдралыг гярхай ажиглаж түүнээсээ дүгнэлт хийж тэр үйл явдлын цаад мөн чанарыг олж түгээмэл шинжтэй нь илрүүлж чаддаг уран чадварыг жүжигчин хүн эзэмших нь чухал. Жүжигчний уран чадвараа дээшлүүлэхэд анхаарах бас нэг чухал асуудал бол үндэстний, түүх, ахуй байдлын, нийгмийн, мэргэжлийн, насны,

хувь хүний онцлогийг сайн судлах мэдэх явдал юм. Мэргэжлийн онцлогоос шалтгаалан хүмүүсийн биеийн байдал, гадна төрх хүртэл тэс өөр байдлыг жүжигчин хүн нэгд нэгэнгүй сайн мэдэж, тоглох дүрдээ тодорхой харуулах хэрэгтэй.

Эмчид жүжигчлэнэ гэхэд зөвхөн ерөнхий эмч биш, мэс засалч юмуу, шүдний эмчийн алин болохыг тодорхой үзүүлж байхад амьдралд ойр дөт болно. Хувь хүний онцлогийг гаргахдаа; Хүн болгон адилгүй гэдэг ардын цэцэн үгийг санаж роль дээрээ ажиллах нь чухал.

Театр урлагийн нэрт найруулагч К. С. Станиславский жүжигчин хүн урлагт байгаа өөрийгөө бус, өөртөө байгаа урлагийг хөгжүүл гэж сургасныг манай жүжигчин, уран сайханчид санаж уран чадвараа ямагт дээшлүүлж ажиллавал зохино.

Ц. ДАЛХСҮРЭН

НАМЫН ДЭЭД СУРГУУЛИЙН 50 ЖИЛИЙН ОЙД

НАМЫН ДЭЭД СУРГУУЛЬ

МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Д. Сүхбаатарын нэрэмжит Намын дээд сургуулийн 50 жилийн ой бол зөвхөн тус сургуулийн хамт олны баяр төдий биш, төгсөгчид, боловсон хүчин, манай орны коммунистууд, нийт ард түмний баяр мөн. Намын дээд сургуулийг байгуулсан явдал эрдэм боловсрол, шинжлэх ухаан техникийн янз бүрийн салбарын өндөр мэдлэгтэй үйлсний сэхээтнүүдийгээр социализмыг байгуулж болохгүй гэсэн их Лениний сургаалыг хэрэгжүүлсэн манай намын холч мэргэн бодлогын биелэл мөн.

Намын дээд сургуулийн туулж өнгөрүүлсэн хагас зуун жилийн түүх нь манай намын үйл ажиллагаа тус орны хөгжлийн түүхэн явцтай салшгүй холбоотой.

1924 оны 4 дүгээр сарын 5-нд «Намын түр сургуулийг» 60-аад сонгогчид той, нэг сарын хугацаатайгаар анх байгуулсан тэр үеэс Намын дээд сургуулийн түүхэн замнал эхэлжээ. Намын түр сургуульд суралцагсад нь намын бодлогыг хөдөлмөрдөд тайлбарлан таниулах ухуулагчийн чиглэлээр бэлтгэгдэж байлаа.

Намын түр сургуулийн

1932 онд, Нам ба улсын төв сургууль болгон өргөтгөжээ.

Хувьсгалын ардчилсан шатнаас социалист шатанд шилжин БНМАУ-ын капиталист биш хөгжлийн замд баттай зогссон үе 1941 онд нам ба улсын төв сургуулийн бааз дээр МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын шинэ хүчний дээд сургуулийг байгуулж, 1943 оны 2 дугаар сард НДС-ийг манай нам, төрийн үндэслэн байгуулагч, тус сургууль байгуулахыг санаачлагч их жанжин Д. Сүхбаатарын нэрэмжит болгожээ.

1924—1941 онуудад нам ба улсын төв сургуулийнхан унагагдсан ангийн зэвсэгт эсэргүүцлийг дарахын хамт МАХН-ын бодлогыг баруун оппортунизмын дайсгалнаас өмгөөлөн, марксист байр суурин дээр бат зогсож, тэднийг үзэл суртал зохион байгуулалтын хувьд бут цохих «үүний» алдаа завхралын хор уршигтай тэмцэн арилгах үйлсэд намдаа идэвхтэй тусласан бөгөөд намын эгнээн нэгдэл нягтралыг хамгаалж нам, ард түмний холбоог бэхжүүлэн хөгжүүлэх үйлсэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

1941—1960-аад онуудад намын шинэ хүчний дээд

сургууль дэлхийн II дайны хүнд бэрх жилүүдэд нам, засгийн улс төр, аж ахуйн бодлогыг ханган биелүүлэх, дайны ялалтыг хангах, түүний хор уршгийг даван туулах, улс ардын аж ахуй, соёлыг жилийн ба хэтийн төлөвлөгөөтэй удирдан хөгжүүлэх, хувийн жижиг аж ахуйтныг социалист ёсоор хоршооллох, улс орноо үйлдвэржүүлэх, соёлын хувьсгал хийх зэрэг эрэмбэ дараатай зорилтыг хэрэгжүүлэхэд нам, улсын удирдах ажилтан олноор нь бэлтгэн өгсөн юм.

Эх орондоо социализм байгуулж дуусгах талаар МАХН-ын IV шинэ программд дэвшүүлэн тавьсан зорилтыг хэрэгжүүлэхэд 1960-аад оноос хойших үед НДС-ийн амьдралд хөгжлийн бас нэг шинэ зурвас үе эхэлсэн бөгөөд өнөө үед НДС нь нам, улс төрийн дээд боловсролтой боловсон хүчин бэлтгэх, улс ардын аж ахуйн салбаруудад ажиллаж байгаа дээд мэргэжилтэй сэхээтэн коммунистуудаас марксист дээд боловсрол, тусгай мэргэжил хосолсон зохион байгуулах арга, удирдлагын ур чадварыг эзэмшсэн удирдах ажилтан бэлтгэх нам, улс, олон нийт, аж

ахуйн байгууллагын удирдах боловсон хүчнийг даван сургах үүрэг гүйцэтгэх болжээ.

Өнгөрсөн 50 жилийн дотор тус сургуулийн үндсэн анги 45 удаа төгсөлт хийж, 3000 гаруй ажилтан бэлтгэж гаргаснаас гадна сургуулийн эцнээ салбар, хоёр жилийн сургууль, түр курсийг олон мянган хүн төгсчээ.

Эдгээр төгсөгчдийн дотор Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга агсан Б. Элдэв-очир, нам, төрийн нэрт зүтгэлтэн, энх тайвныг бэхжүүлэхийн төлөө Лениний шагналт Ж. Самбуу, намын ахмад ажилтан Б. Банзрагч, партизан С. Жамсран, эмэгтэй Цэрэнлхам, гавъяат нисгэгч С. Лхагважав нарын зэрэг ахмад үе, мөн МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга С. Жалан-аажав, МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны орлогч гишүүн, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга Т. Рагчаа, БНМАУ-ын Ардын Хянан Шалгах Хорооны дарга Л. Дамдинжав, зохиолч С. Удвал, С. Дашдэндэв, ШУА-ын сурвалжлагч гишүүн, төрийн шагналт Э. Шагдар нарын зэрэг нам, төр, олон нийт, урлаг, утга зохиол, шинжлэх ухааны нэрт зүтгэлтэн, эрдэмтэд, эх орныхоо социализмын байгуулалтын түргүүн эгнээнд явж намынхаа даалгаврыг нэртэй биелүүлж байгаа БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Г. Лодойхүү, Д. Арьяа, У. Доржпалам, Б. Лувсан, Ч. Чулуун, Төв аймгийн Утгаалын САА-н дарга Б. Батчулуун, Жаргалантын САА-н намын хорооны нарийн бичгийн дарга Н. Дашням нарын зэрэг олон арван сайчууд төрөн гарсан юм.

Тус сургуулийг төгсөгчид улс орны хөгжлийн тухайн үеийн шаардлагаар янз бүрийн ажил үүрэг гүйцэтгэж байгаа боловч тэд МАХН-ынхаа улс төрийн бодлого, жанжин шугамын төлөө хэзээ ямагт тууштай зогсож, шинэ амьдрал байгуулахын төлөө эх орныхоо хөгжил цэцэглэл, ард түмнийхээ сайн сайхны төлөө бэрхшээлийг сөрөн тэсвэр хатуужилтай тэмцэн, учраа мэдсэн сахилга баттай, зохион байгуулалтай байдаг намын ажилтны эрхэм нандин чанарыг шингээсэн нийтлэг шинж чанартай байхын үлгэр жишээг үзүүлж байдаг билээ.

Тус аймгийн ХАА, үйлдвэр, соёл, боловсрол, эрүүлийг хамгаалах салбаруудын ажил үйлсийн амжилт бүтээл нь Намын дээд сургуулийг янз бүрийн хугацаагаар төгсгөөд манай аймагт ажиллаж байгаа 100-гаад хүмүүсийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой.

Намын дээд сургуулийн хагас зуун жилийн ой угтсан хөдөлмөр тус аймагт идэвхтэй өрнөж, аймгийн аж ахуй, соёлын эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлд чухал нөлөө үзүүлэв. Тус сургуулийг төгсөгчид болой суралцагсад нийт боловсон хүчин бүр өөрсдийн улс төр, онолын бэлтгэл, ажил хэргийн мэдлэгээ цуцалтгүй дээшлүүлэн, намаас боловсон хүчний өмнө тавьж байгаа зарчимт шаардлагыг биелүүлэх талаар ямагт үлгэр дуурнал болж, ойрын үед болох нам ард түмний түүхт их ойнуудыг угтсан ажил, улс ардын аж ахуй соёлыг хөгжүүлэх V таван жилийн төлөвлөгөөт зорилтыг чанарын бүрэн сайн үзүүлэлтээр ханган биелүүлэх нь дамжиггүй.

Р. ЧИМЭДЦЭРЭН

ОЮУТНЫ ШИРЭЭНЭЭС АМЬДРАЛЫН ИХ СУРГУУЛЬД

Намар, Утгаалцайдамын уудам хөндий алтны сан гэдтэй шаргалтана.

Дөрвөн мянгаад га баян нутаг 1961 оноос эхлэн өндөр ургац, атрын залуусын алдраар гэрлэтэх болсон юм.

Энэ тариалангийн тал бараас БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, улс аймгийн аварга олноор төрж зөвхөн өндөр ургацын 1973 онд, улсын бүх төлөвлөгөөт ургацын 10 хувьтай тэнцэх тариа хурааж, МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МҮЭ-ийн Төв Зөвлөл, МХЗЭ-ийн Төв Хорооноос зарласан уралдаанд 2 тасаг, 11 бригад байр эзэлж «УАЗ-

452» машин 2, мотоцикл 11-ээр шагнагджээ.

Утгаалын САА-н аль ч замаар явсан тариалангийн талбай бүрээс их амжилтын эзэд угтан золгоно. Талбайгаас талбай тариачин хүмүүст хүрсэн энэ замыг анх Батчулуун дарга гаргасан юм.

Атар эзэмших аянд залуус мсрдож байсан 14 жилийн тэртээ МХЗЭ-ийн Төв Хорооны суртал соёлын хэлтсийн эрхлэгч Б. Батчулуун залуустайгаа хамт атар эзэмшихэд авъяас чадлаа сорих даалгавар намаасаа авчээ.

Залуу коммунист Б. Батчулуун анх 27 трактор,

Төгсгөл нь IV нүүрт

АЧИЙН МАРТАХГҮЙ



Доржот аймгийн ХЗЭ-ийн хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга байхдаа би 1947—1950 онд МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын шинэ хүчний дээд сургуульд эцнээгээр суралцан төгссөн юм. Намын дээд сургуульд суралцах хугацаан-

даа улс төр, онолын мэдлэг эзэмшихийн зэрэгцээгээр сургуулийн нарийн чанд журам дэглэм, сонгогчдын хатуу сахилга, намч өндөр зарчимтай танилцан түүнийг суралцан гарсан билээ.

Намын дээд сургуулиас сурсан бүх мэдлэг сурлага маань миний ажил амьдралын бүх замыг гийгүүлж, социалист ХАА-н үйлдвэрлэлийг олон жил үр бүтээлтэй удирдаж БНМАУ-ын хөдөлмөрийн баатар гэдэг эрхэм өндөр хайр шагналыг хүртэхэд шийдвэрлэх суурь нь болсон юм. Би өөрийн ололт амжилт бүхнээ хайрт сургуулийнхаа ач гавьяа гэж үздэг. Биднийг суралцаж байх үед багш Жалан-аажав, Камбар, Сонговай,

Авирмэд, Шагдар, Дулмаа, манай эцнээ салбарын захирал байсан БНМАУ-ын гавъяат багш Жамьяндагва нарын олсн багш эрдэмтэд мэргэжил мэдлэг цаг хүчээ хайрлах гүйгээр сэтгэлчлэн туслаж байсны ачаар бид сургуулиа амжилттай төгссөн билээ. Нам, ард түмнийхээ үйл хэргийн төлөө өөрийн бүх мэдлэг хүчээ үүрд зориулан шан таршгүй зүтгэх ухамсар мэдлэгийг над эзэмшүүлэн өгсөн хайрт сургууль, ачит багш нартаа сургуулийнхаа алдарт 50 жилийн ойг тохиолдуулантай лархал илэрхийлж, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Намын дээд сургуулийн ахмад сонгогч, Жаргалантын САА-н дарга, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Д. АРЬЯА

Намын дээд сургуулийн хүндэт дэвтэрт бичигдэгсдийн дотор тус аймгаас Сүхбаатарын цалинт, онц сурлагатай Я. Дамдинсүрэн байв.

Тэр манай мянга мянган оюутны ижил жирийн хүн—эрдмийн эрэлчин байлаа.

Оюутны хөдөлмөр бол мэдлэгийн гүн тийш давших уурхайчны ажил юм.

Шинэ мэдлэгийн төлөө давшилтанд Я. Дамдинсүрэн найдвартай амжилтаараа оюутан нөхдөө тэргүүлж сурч төгсөх хугацааных нь 41 удаагийн шалгалт шүүлэгт Монгол, Зөвлөлтийн профессор эрдэмтэн багш нар «онц» гэдэг эрхэм дүнгээ өгчээ.

Онол мэдлэгийнхээ хүрээт тэлэн гүнзгийрүүлэх их боломж болсон оюутны чөлөө цаг ашиглах хувийн нарийн төлөвлөгөө нь түүнд сонссон лекцээ өөрийн болгон боловсруулах, эх зохиол

дээр ажиллах, нөхөдтэйгээ зөвлөн давтах олон хэлбэрийн ятаршгүй хөдөлмөрөө эрдмийн нь санг баяжуулж тийнхүү тэргүүн үнэлэлтэд хүргэжээ.

Я. Дамдинсүрэн улс төрийн боловсролоор гарганзаганд хүргэсэн сургуулийнхаа тухай «Манай сургууль оюутнуудад

оюутны хурлаар Сүхбаатарын цалинд нэр дэвшигдэж, Курсийн намын үүрийн даргаар сонгогдож, МАХН-ын XVI их хуралд оролцох уриалга гаргаж, сургуулийн тусгай даалгавраар Говь-алтай аймгийн Тайшир суманд очиж, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Г. Лодойхүүгийн амьдралын

хичээл эхлээд 20 хоносын дараа нэг хүүг хөтсөн з а х и р а л дээр авчирч 1-ээс шууд 3 дугаар ангид дэвшүүлэн суралцуулах болсон нь Я. Дамдинсүрэн байлаа. Тэр долоотойдоо шинэ, хуучин үсэг хэдийн сурч «Болд хэрхэн хатагдсан нь» романыг уншин дуусгаж уран зо-

түүхэн үед ард нийтийг зохион байгуулан удирдахад авьяас чадвараа сорьсон аж.

1954 оноос Баянчандмань сумын нарийн бичгийн болон орлогч дарга, тэндээс Угтаацайдам сумын намын хороо, Өнжүүл сумын намын үүрийн даргаар ажиллаж удирдан зохион байгуулах ажлын багагүй туршлага хуримтлуулжээ.

Тэр амьдралын энэ их практикаа Марксист-Ленинист онолтой холбож эх орондоо ихийг бүтээх хүсэлдээ хөтлөгдөн 1969 онд НДС-д орж тийнхүү суралцан төгсөөд эрдэм боловсрол олгосон нам, з а с а г, сургуулийнхаа ачийг коммунист хүний ажилч хичээнгүй хөдөлмөрч зүтгэлээр хариулахаар шамдаж явна.

Я. Дамдинсүрэн одоо тус аймгийн Намын хорооны үзэл суртлын хэлтсийн эрхлэгчээр ажиллаж байна.

Ш. ЦЭРЭНДОО

Сүхбаатарын цалинтан

Мэлгээдэл

онол улс төрийн мэдлэг олгохоос гадна коммунист хүний эрхэм нандин шинжийг төлөвшүүлэхэд сүрлэг сайхан ахуйгаараа ямагт нөлөөлдөгөөрөө бусдаас онцгой гэж бахархан ярих дуртай.

Я. Дамдинсүрэн жанжины нэрэмжит дээд сургуульд орж эрдмийн мөр хөөсөн тэр жилүүдэдээ

замнал ажлын туршлагаар «Хөдөлмөрийн үр-шим» сэдэвт курсийн ажлаа бичиж НДС-ийн хүндэт дэвтэрт бичигдэж бахархалтай сайхан үйл явдалаар намтар нь зузаарсан байна. Ер нь түүний намтар анхнаасаа жирийн атлаа сонирхолтой юм.

Тээр жил, Батсүмбэр сумын бага сургуулийн багш Ө. Балжинням гуай

хиолын бусад баатруудтай танилцахаар тэмүүлж байсан учир тийн дэвшин сурсан аж.

Я. Дамдинсүрэн 7 дугаар анги төгссөнийхөө дараа 18 настай, 1952 онд Өлийн 56 дугаар нэгдлийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргын үүрэгт ажлаар хөдөлмөрийн их замаа эхэлжээ. Тэрээр ид нэгдэлжих

Статистикийн алба байгуулагдсаны 50 жилийн ойд

БҮРТГЭЛИЙН АЖИЛ, ШАГНАЛ УРАМШИЛ

Улс ардын аж ахуйн салбаруудын нягтлан бодох, статистик бүртгэл, санхүүгийн ажилд шагнал урамшуулалтын олон хэлбэр үйлчилж бүртгэл тооцооны ажилд тэргүүний арга туршлага хуримтлагдан хөдөлмөрийн бүтээмж нь өссөөр байна.

1950-иад оноос эхлэн нягтлан бодох бүртгэл тооцооны ажилд урамшуулалтын арга хэмжээг боловсруулан хэрэглэсний дээр 1965 онд нягтлан бодохын тайлан балансын шагналын шинэчлэгдсэн зааврыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс батлан мөрдүүлсэн билээ.

1964 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 111 дүгээр тогтоолоор тоо бүртгэлийн тэргүүний ажилтан нарыг шагнахад зориулан Статистикийн Төв Газрын даргын мэдэлд жил бүр фонд байгуулж байхаар тогтоосон юм. Энэ тогтоолыг биелүүлэхтэй холбогдуулан бүртгэл мэдээллийн ажилд идэвхтэй ажилласан хүмүүсийг шалгаруулан шагнаж байх заавар батлагдаж уул зааврын шаардлага хангасан сумдын төлөвлөгөө статистик эрхэлсэн орлогч дарга, САА, ХАА-н нэгдэл, албан үйлдвэрийн газрын дарга, нягтлан бодогч, тоо бүртгэл харууссан хүмүүсийг бүтэн нэг жилийн ажиллагаагаар нь шалгаруулан шагнаж байхаар заасан билээ.

Энэ зааврын дагуу 1965 оноос эхлэн уг шагналыг Статистикийн Төв Газраас олгож байгаа бөгөөд одоо уул шагналаар улсын хэмжээгээр нэг мянга шахам хүн, манай айм-

гаас 100 шахам хүн шагнагдаад байгаа юм.

Бүртгэл тооцоо, статистикийн ажилтны дунд мөнгөн шагналын систем ийнхүү нэвтэрч байгаагийн гадна оюун санааны урамшуулалт ихээхэн роль гүйцэтгэж байна. 1964 оноос тус улсын санхүү мөнгөн зээлийн системийн ажлыг хөгжүүлэн бэхжүүлэх хэрэгт удаан жил идэвх зүтгэлтэй ажилласан тэргүүний хүмүүсийг шагнаж байх «Санхүү банкны тэргүүний ажилтан» тэмдэг, 1971 онд «Гавьяат эдийн засагч» цол, 1972 онд «Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан» тэмдэг бий болгов. Эгнээндээ 13 мянга гаруй ажилтантай бүртгэл тооцооны армид одоо хэд хэдэн гавьяат эдийн засагч, банк санхүү, статистикийн олон арван тэргүүний ажилтантай болсон юм. Материалын болоод оюун санааны урамшуулалт үр дүнтэй үйлчилсний үрээр Статистикийн Төв Газар төвлөрүүлэн авдаг бүх мэдээний тоо 1963 оноос 4 дахин өсч одоо жилд 20 мянга шахам мэдээ хүлээн авч бүх төрлийн бүртгэлийн хөтлөлт, мэдээний гаргалт сайжирсаар байна.

Энэ бүхэн нь мэдээ тооцооны ажилд төв ба үндсэн байгууллагуудаас тавих анхаарал сайжирч бүртгэлийн ажилтны гүйцэтгэх ажлын хүрээ хэмжээ, техник ажиллагаа ихээхэн өсч буйг харуулж байгаа юм. Иймээс бүртгэл статистикийн ажилтны шагналын хамрах хүрээг өргөжүүлэх зорилгоор БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс 1973 онд

статистикийн бүртгэлийн ажлыг сайжруулан анхан шатны бүртгэлийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, улсын тайлан мэдээг график хугацаанд нь үнэн зөв гаргаж судалгаа дүгнэлт хийн түүний мөрөөр тодорхой ажил зохиож, статистикийн бүртгэлийн ажилд амжилт гаргасан тэргүүний хүмүүст мөнгөн шагнал олгож байх тухай тогтоол гарснаар нягтлан бодохын тайлан балансын шагналд орохгүй орхигдож байсан статистикийн бүртгэл гардан хөтлөгчид байнгын шагналд хамрагдаа. Мөн МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1966 оны 75/78 дугаар тогтоолоор аам, тусгай газар, үйлдвэр аж ахуйн байгууллагын статистикийн бүртгэлийн ажлыг нягтлан бодох ангид харууцуулсантай холбогдуулан нягтлан бодохын тайлан балансын шагнал олгох журмын тухай зааварт статистикийн бүртгэлийн тайлан мэдээг график хугацаанд нь үнэн зөв, бүрэн үзүүлэлтээр гаргаж тогтмол мэдээлсэн байхын хамт тайлан балансыг мэдээний уялдаа холбоо чанарыг сайжруулж статистикийн тайлан мэдээ гардан хөтлөж байгаа агуулахын эрхлэгч, тасаг, цехийн дарга, мастер, бригадын дарга, аж ахуйн эрхлэгч зэрэг бүртгэл харууссан хүмүүст шагнал олгож байхаар нэмэлт оруулсан билээ. Шагналын эдгээр хэлбэрүүдийг оновчтой зөв хэрэглэн бүртгэлийн ажилтнуудын идэвхи санаачлагыг дээшлүүлэн бүртгэл тооцооны ажлыг эрс сайжруула.

Д. ЛУУШ

ОЮУТНЫ ШИРЭЭНЭЭС АМЬДРАЛЫН ИХ СУРГУУЛЬД

төгсгөл. (Түрүүч нь III нүүрт) 76 залуу дагуулж Угтаа-лын уудам хөндийд ирж анхны шаа болгоныг тавилдаж, шан бүрийг татуулж газар бүрээс ирсэн залуусын хүсэл бодлыг атар эзэмших нэгэн зорилгод зангидсан болохоор тэр мөр бүр нь өөрийн шинэ баатруудын намтар баян зам болон тодорчээ. Алдар гавьяаны тэр замын эзэд жилдээ 22,3 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж САА нь одоо үр тарианы 3 тасаг, 13 бригадтай тэдний төвх өрчин үеийн тохилог суурин болтлоо хөгжжээ.

Тэд бүх ажлаа орчин цагийн өндөр бүтээлтэй техникээр амжуулдаг. Энэ САА-н тулган чулууг нь тулалдсанаасаа эхлэн Б. Батчулуун 14 дэх жилдээ даргалж байна. Анх майхантай очсон залуус, машинтай боло-

хоос эхлээд САА-н төв босгож атрын хөндийг тарианаар найгуулан өдий том аж ахуй болтол нь удирдан зохион байгуулсан нь түүний оюутны ширээнд олсон онол мэдлэгээ хөдөлмөрийн талбарт яаж хэрэгжүүлснийх нь баталгаа юм.

Тэр, Намын дээд сургуульд сурч байхдаа оюутнуудын оргилуун сэтгэлээр чухам ингэж ажиллахыг хүсч тэр хүсэл нь ч энэ дуудга ирүүлжээ. Тэгээд Батчулуун санасандаа хүрч тохиолдож байсан бэрхшээлүүд нь удирдахуйн арга барилыг нь баяжуулж хашир туршлага суулгасан агаад бүтээлч үйл ажиллагаа нь түүний энгэрт Сүхбаатарын одонгоос эхлээд олон медаль, БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатын алтан соём бот тэмдэг болон гялалцаж байна.

Байгаль хамгаалах сард

ОЙН ИХ ӨГӨӨЖ

Ой мод эдийн засаг, хүн амын хэрэгцээ, хүрээлэн байгаа орчныг сайжруулахад үнэлж баршгүй ач холбогдолтой юм. Нэг шоометр модноос химийн аргаар иж бүрэн боловсруулсны дүнд хиймэл торго 160 кг, мяндсан утас 1500 метр, кос-тум 600, шаахай 180, торгон оймс 400 хос, цаас 200, хиймэл ноос 170 кг, автомашинд хэрэглэгдэх резинэн дугуй 2 хос, этилийн спирт 90 литр, хальсан цаас 6000 метр зэрэг чухал бүтээгдэхүүний

аль нэгийг гарган авч болно. Мөн нэг тонн хуурай уртсээр спирт үйлдвэрлэхэд улаан буудай 400 кг, төмс 2 тоннныг хэмнэж болох ба 180 литр спирт гарган авна. Нэг тонн хуурай модлог, агаараас 2 тонн орчим нүүрс-төрчийг шингээн авч, 1 тонн гаруй цэвэр хучил-төрчийг ялгаруулдаг байна.

Ой мод хот, суурины орчны агаарыг 35 хувь цэвэржүүлж, бас дуу чимэг 26 хувь хүртэл хо-рогдуулдаг аж.

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ